



МОНГОЛ УЛС  
ХЭНТИЙ АЙМГИЙН ЗАСАГ ДАРГЫН  
ЗАХИРАМЖ

2021 оны 02 сарын 17 өдөр

Дугаар А/84

Чингис хот

Ажлын хэсэг байгуулах тухай

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 29 дүгээр зүйлийн 29.2, Газрын хэвлийн тухай хуулийн 7 дугаар зүйл 7.2.1, 7.2.3, Ашигт малтмалын тухай хуулийн 12 дугаар зүйлийн 12.1.1 дэх заалтыг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1. Аймгийн нутаг дэвсгэрийн хэмжээнд хууль бус ашигт малтмалын хайгуул, ашиглалт хийсэн газрыг нөхөн сэргээх, цаашид тухайн газрыг орон нутгийн өмчид авч ашиглах асуудлыг судалж танилцуулах ажлын хэсгийг доорх бүрэлдэхүүнтэй байгуулсугай.


Ажлын хэсгийн ахлагч:	Ж.Ганбаатар	Аймгийн Засаг даргын Тамгын газрын дарга
Нарийн бичгийн дарга:	Б.Дарханбаатар	Аймгийн Засаг даргын Тамгын газрын Хууль, эрх зүйн хэлтсийн дарга
Гишүүд:	С.Амгаланбаатар	Мэргэжлийн хяналтын газрын Байгаль орчин, дэд бүтэц, хөдөлмөрийн хэлтсийн дарга
	Ө.Оюунсүвд	Аймгийн Засаг даргын Тамгын газрын Хууль, эрх зүйн хэлтсийн мэргэжилтэн
	Б.Мөнхжаргал	Аймгийн Засаг даргын Тамгын газрын Хөрөнгө оруулалт, хөгжлийн бодлого төлөвлөлтийн хэлтсийн Байгаль орчин, аялал жуулчлал, уул уурхайн бодлого хариуцсан мэргэжилтэн
	Г.Мөнх-Эрдэнэ	Байгаль орчин, аялал жуулчлалын газрын Уул уурхай, тусгай хамгаалалттай газар нутаг хариуцсан мэргэжилтэн
	О.Сэдэд	Орон нутгийн өмчийн газрын Өмчийн бүртгэл, ашиглалт хяналтын мэргэжилтэн,

231010251

2.

2. Дээрх ажлыг төлөвлөгөөний дагуу үр дүнтэй зохион байгуулж, хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг ажлын хэсгийн ахлагч аймгийн Засаг даргын Тамгын газрын дарга /Ж.Ганбаатар/-д даалгасугай.

ЗАСАГ ДАРГА



Ц.ИДЭРБАТ